



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 14-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Говь ХК-ийн 2021 оны санхүүгийн үр дүнг харгалзан, Компанийн тухай хуулийн 46.5, 46.6, 47.1 дүгээр заалт болон Компанийн дүрмийн 8.9, 8.12 дэх заалт, Ногдол ашгийн журмын 3.1 дүгээр заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК нь 2021 оны санхүүгийн үр дүнд компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Говь ХК нь хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д даалгасугай.

Гурав. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

